



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Бага тойруу 13/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: (976-11) 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,

Цахим шуудан: undeg@ndaatgal.mn,

Цахим хуудас: www.ndaatgal.mn

2026.04.27 № 04/1129

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу

Тус газарт хандаж ажил олгогчоос ажилтанд олгож байгаа хоолны үнийн хөнгөлөлтийг бэлэн мөнгөөр бус нэгдсэн системээр дамжуулан ажил олгогчтой гэрээ байгуулсан хоолны газруудаар үйлчлүүлэх эрх бүхий цахим купонд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах эсэх танай тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлд Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, Иргэний хуулийн 343 дугаар зүйлд заасан ажил гүйцэтгэх, 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс, ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулалд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулан төлөхөөр заасан.

Иймд ажил олгогчоос ажилтандаа хоолны үнийн хөнгөлөлтийг купоноор олгож байгаа тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй.

Хүндэтгэсэн,